

Лондон хотноо болсон Хөрөнгө оруулагчдын чуулган дээр Оюу Толгой ХХК-ийн Ерөнхийлөгч бөгөөд Гүйцэтгэх ерөнхий захирал Камерон МакРейн хэлсэн үг

Би өнөөдөр Оюу Толгой болон Рио Тинтог төлөөлж энд ирсэндээ баяртай байна. Монгол гэдэг гайхалтай улсад зочилж амжаагүй хүмүүст хэлэхэд Монгол улс та бүхнийг халуун дотноор угтах бөгөөд тэнд гайхамшигтай өв бий болгож, бүтээх хүсэл тэмүүллээр жигүүрлэсэн улс орон, хүмүүсийг харж болно.

Оюу Толгойн хувьд 2013 он бол өнөөдрийн хүрсэн, цаашид хүрэх ололт амжилтын онцгой ач холбогдолтой жил юм. Бид энэ оны эхээр анхны зэсийн баяжмалаа үйлдвэрлэсэн. Ирэх 6 дугаар сарын сүүлчээр бүтээгдэхүүнээ зах зээлд нийлүүлэхээр төлөвлөж байна.

Монгол улсын Засгийн газартай түншлэсний үр дүнд манай ажилчид өмнийн говьд томоохон амжилтад хүрсэн. Бид ямар ч дэд бүтэцгүй говь нутагт ердөө 30 сарын хугацаанд уул уурхайн хамгийн сүүлийн үеийн дэвшилтэт цогцолбор барьж чадлаа.

Оюу Толгойн баяжуулах үйлдвэр ашиглалтад ороод ажиллаж байна. Энэ үйлдвэр Монгол улсын хамгийн том үйлдвэрлэлийн байгууламж. Ил уурхайгаас баяжуулах үйлдвэр хүртэл хүдэр зөөх туузан дамжуурга нь Кенсингтон Хай гудамжны уртаас хоёр дахин урт гэхээр ямархуу том бүтээн байгуулалт тэнд өрнөсөн гэдгийг та мэдэх биз ээ.

Манай уурхайд зочилж буй хүмүүс тэнд ямархуу цар хүрээтэй, том бүтээн байгуулалт бий болсныг хараад үнэхээр биширдэг. Гэхдээ юу чухал вэ гэвэл Оюу Толгойн үйл ажиллагаанаас ард иргэдийн болон улс орны эдийн засагт үзүүлэх эерэг нөлөөлөл нь чухал ач холбогдолтой.

Монгол улсын түүхэн дэх хамгийн том хөрөнгө оруулалт бүхий Оюу Толгой нь ДНБ-ий 30 хувийг бүрдүүлэх тухай тооцоо бий. Манай уурхай бүтээгдэхүүнээ үйлдвэрлэж зах зээлд нийлүүлж эхлэхээс өмнө Монгол улс уурхайн ашиг шимийг хүртээд эхэлсэн.

Жилд ойролцоогоор 4.5 тэрбум ам.долларын төсөвтэй Монгол улсын Засгийн газарт бид барилгын ажлаа эхлүүлснээс хойш татвар, урьдчилгаа төлбөр, бусад хураамж хэлбэрээр 870 гаруй сая ам.доллар төлөөд байна.

2012 онд Рио Тинто компанийн дэлхийн улс орнуудад төлсөн татварын хэмжээг харьцуулж үзэхэд Монгол улсад төлсөн татвар эхнээсээ тавд багтсан юм. Ашиг, орлого олоогүй байхдаа энэ татварыг төлсөн учраас ихээхэн ач холбогдолтой юм.

Оюу Толгойн бүтээн байгуулалт болон улсад төвлөрүүлж буй татвар хураамж нь Монгол улсын Засгийн газарт чухал ач холбогдолтой. Энэ бүтээн байгуулалт бас хүмүүсийн амьдралд ч шууд нөлөө үзүүлж байна.

Орон нутгийн иргэдэд ашиг тусаа өгөх өргөн цар хүрээтэй дэд бүтцийг бид өмнийн говьд сүндэрлүүлж байна. Хилийн боомт руу барьсан засмал замаар баяжмалаа зөөж, зах зээлд

гаргахаас гадна үүнийг нийтийн тээвэрт ашиглаж хүмүүсийг аюулгүй, түргэн шуурхай аялах боломжийг бүрдүүлэх юм.

Эрчим хүчний дэд бүтэц нь уурхайг ажиллуулахад зорилготой ч энэ нь Монгол улсын цахилгаан эрчим хүчний сүлжээний чухал бүрэлдэхүүн хэсэг болохоос гадна уурхайн орчмын сумын төв, айл өрхийг цахилгаанаар хангах давуу талыг бий болгож байна.

Шинээр барьсан нисэх буудал нь уурхай болон Улаанбаатар хотын хооронд зорчих, холыг ойртуулж, хоёрыг уулзуулах шинэ гарц болж байна.

Монгол улсын хөгжилд үнэ цэнтэй хувь нэмэр оруулж буй олон үйл ажиллагааг нэрлэж болно:

Боловсрол, сургалтын хөтөлбөр: Бид Монгол улсын Засгийн газартай хамтран боловсрол, сургалтын салбарт 126 сая ам.долларын хөрөнгө оруулалт хийж, мэдлэг туршлагыг дэлгэрүүлж байна. Олон мянган Монгол залуусыг сургах Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвүүдийг барьж, сургалтын хөтөлбөр боловсруулж, багш нарын ур чадварыг сайжруулж байна. Энэ хөтөлбөрийн хүрээнд Монгол улсын ирээдүйн техник, мэргэжлийн ур чадвартай ажиллах хүч, удирдагчдыг хөгжүүлж зөвхөн уул уурхайн салбарын төдийгүй, инженер, барилга, санхүү, мэдээллийн технологи зэрэг бусад салбарын дэлхийн түвшний ажиллах хүчийг бий болгож, улсын хэмжээнд бизнесийн байгууллагуудад ашиг тусаа өгч байна.

Бүс нутгийн хөгжил: Уурхайг барьж байгуулахад урган гарч буй орон нутаг болон компанийн хоорондын хамтын үр өгөөжийг дурьдах нь зүйтэй. Оюу Толгой өмнийн говийн бүс нутгийг хөгжүүлэхэд нэлээдгүй хөрөнгө оруулалт хийгээд байна. Сургууль, эмнэлэг барьж, ундны усны хангамжийн дэд бүтцийг сайжруулж, эрүүл мэндийн хөтөлбөр хэрэгжүүлж, өмнийн говийн соёлын өвийг хадгалж, хамгаалах үйл ажиллагаанд бидний хөрөнгө оруулалт чиглэж уурхайтай хөрш зэргэлдээ орших нутаг орон, ард иргэдэд ашиг тусаа өгч байна.

Ханган нийлүүлэлтийн сүлжээний хөгжил: Монгол улсад бизнесийн чадавх сайжрах тусам Оюу Толгой илүү үр дүнтэй үйл ажиллагаа явуулж чадах юм. Энэ бол аль болох олон төрлийн бараа бүтээгдэхүүн, үйлчилгээг дотоодын зах зээлээс худалдан авч, ханган нийлүүлэгч үндэсний компаниудыг өсөж хөгжихөд нь нэмэр болохуйц санхүүгийн болон техникийн туслалцаа үзүүлнэ гэсэн үг юм. Өнөөдрийн байдлаар манай нийт ханган нийлүүлэгчдийн 67 хувь нь Монголын компаниуд байгаа нь бидний бахархал. Бидний дэмжиж, тусалж байгаа эдгээр компаниуд өөр бусад төслүүд болон хөрөнгө оруулагчидтай ажиллах ур чадвар, нөөц бололцоотой болж хөгжиж байна.

Монгол улсад оруулсан 6.2 тэрбум ам.долларын хөрөнгө өөр бусад олон компаниудыг санхүүгийн үйлчилгээ, ханган нийлүүлэлт, инженеринг, зочид буудал, үйлчилгээний салбарт хөрөнгө оруулалт хийхэд хөтөлсөн билээ. Энэ нь Оюу Толгойг хамтран бүтээн байгуулж буй Монгол улсын Засгийн газар цаашдын өсөлт хөгжлөө төлөвлөж, шинэ төслүүдэд хөрөнгө оруулалт хийх боломжийг бүрдүүлсэн.

Дараагийн үе шат

Оюу Толгой өнөөдрийн байдлаар эхний үе шатны үйл ажиллагаагаа ардаа орхиход тун ойртоод байна. Мөн зах зээлд бүтээгдэхүүнээ нийлүүлэх ажил энэ оны дундуур эхлэхээр төлөвлөгдсөн. Оюу Толгой уурхай бүрэн хүч чадлаараа ажиллахын тулд дараагийн үе шатанд шилжих шаардлагатай.

Газрын гадаргад ойролцоо ил гарсан ашигт малтмалын илрэл он цагийн явцад гадаргыг оюу номин өнгөтэй болгосон нь Оюу Толгой гэсэн нэрийн учир шалтгаан болж өгсөн. Мөн энэ л оюу өнгийн толгод өнөөгийн Оюу Толгойг нээж илрүүлэхэд түлхэц, дэм болсон юм.

Оюу Толгойн хүдрийн биетийн дийлэнх нь буюу нийт үр ашгийн 80 хувийг далд уурхайн аргаар гаргаж авах юм. Эдгээр өндөр агуулгатай ордууд Нью-Йоркийн Манхаттэн аралтай ойролцоо хэмжээтэй юм.

Оюу Толгой томоохон барилгын төслөөс дэлхийн түвшний уул уурхайн үйлдвэрлэл рүү шилжиж байна. Оюу Толгойн далд уурхайг бүтээн байгуулж, ашиглаж эхэлсэнээр хувь нийлүүлэгчид үр ашгаа хүртэхээс гадна Монгол улсын ДНБ 20 хувиар нэмэгдэж, улмаар Монгол улсын Засгийн газарт 34 тэрбум гаруй ам.долларын хувь нэмрийг шууд оруулах юм.

Гэхдээ далд уурхай барьж байгуулах нь тийм хямд, амар хялбар биш юм. Оюу Толгой ил уурхайгаасаа 2013 оны хоёрдугаар хагасаас орлого олж эхлэх ч, газрын гүнд далд уурхайн бүтээн байгуулалт болох 250 км урт нүхэн гарц, тунелийг барьж байгуулахын тулд ихээхэн хэмжээний хөрөнгө мөнгө босгох шаардлага гарч байна.

Төслийн санхүүжилтийг банкны эх үүсвэрээр бүрдүүлэх нь үнэ өртгийн хувьд хамгийн тохиромжтой хувилбар юм. Төслийн санхүүжилтийн энэ ажил ихээхэн ахицтай байгааг та бүхэнд хэлэхэд таатай байна.

Оюу Толгой төслийн хоёрдугаар үе шатыг барьж байгуулах олон тэрбум ам.доллараар хэмжигдэх энэхүү санхүүжилт нь Монгол улсад эдийн засагт өргөн цар хүрээнд үр өгөөжөө оруулахаар байна. Засгийн газар цахилгаан станц, уул уурхайн бусад төсөл, үйлдвэр, орон сууц, зам, төмөр зам зэрэг томоохон төслүүдийг барьж байгуулахад 30 гаруй тэрбум ам.долларын хөрөнгө оруулалт хийх тухай яригдаж байна.

Энэ бүх төслүүдэд хувьцааны санхүүжилт, эсвэл зээлээр хэлбэрийн олон улсын санхүүжилт шаардлагатай. Монгол улс бол хөрөнгө оруулалт хийхэд таатай нөхцөлтэй, найдвартай гэсэн мессежийг олон улсад өгч буйгаараа Оюу Толгой төслийн санхүүжилт нь ховор боломж юм. Дэлхийн шилдэг хорь гаруй банк, санхүүгийн байгууллагын анхаарлыг Монгол улс руу татсанаар бид хамтдаа Монгол улс бол олон улсын хөрөнгө оруулалтыг татах тааламжтай орон гэсэн мессэж өгч байна.

Одоо явагдаж буй хэлэлцээр

Өнгөрсөн намар би Гонконгт болсон хуралд манайхтай адил төслүүдийн эдийн засгийн ашиг тусын талаар Оюу Толгойн байр суурьнаас илтгэл тавихдаа Монгол улсын ирээдүйн

хөгжил, цэцэглэлт өргөн хүрээний хөрөнгө оруулалтаас хэрхэн шалтгаалах талаар дурьдсан.

Монгол улсын эдийн засаг өсөн хөгжиж, цэцэглэж, төрөлжих нь Оюу Толгойн эрх ашигт нийцэж байгаа. Гэхдээ бид бусад компаниудыг зөвхөн уул уурхайн салбарт төдийгүй өөр бусад олон салбарт хөрөнгө оруулалт хийхэд хөтлөхийн тулд Оюу Толгой өөрөө хөгжин, цэцэглэх шаардлагатай гэдгийг мэдсэнээрээ тодорхой үүрэг хариуцлага хүлээж байгаа билээ.

Мэдээж та бүхэн сүүлийн саруудад Засгийн газрын зүгээс Оюу Толгойн Хөрөнгө оруулалтын гэрээний хэрэгжилтийн талаар хөндөж тавьсан асуудлуудыг уншсан байх.

Би тодорхой хэлье. Оюу Толгой, олон улсын хөрөнгө оруулагчид, Туркуаз Хилл, Рио Тинто компаниуд болон Монгол улсын Засгийн газар бүгдээрээ адилхан нэг зүйлийг хүсэж байгаа. Энэ бол хувь нийлүүлэгчиддээ ашиг авчирч, Монгол улсад хөгжил цэцэглэлт, гэрэлт ирээдүйг авчрах дэлхийн түвшний уурхайг хөгжүүлэх тухай юм. Мэдээж Оюу Толгой Монгол улсын хувьд ихээхэн чухал.

Тиймээс хувь нийлүүлэгчдийн дунд байгаа аливаа асуудлыг төслийг хамтран хэрэгжүүлж буй талуудын дунд ярилцаж, шийдэж байх нь чухал юм. Монгол улсын Засгийн газар болон Рио Тинто, Туркуаз Хилл компаниуд нь Монгол улсын болон хувь нийлүүлэгчдийн урт удаан хугацааны ашиг, тусын тулд эдгээр асуудлыг хамтран шийдэж байгаа нь ихээхэн чухал юм.

Ахиц, дэвшил гарч байна. Өнөөг хүртэл явж ирсэн үйл ажиллагаанаас гадна үйлдвэрлэл болон цаашдын бүтээн байгуулалтыг хослуулан явуулах тал дээр анхаарлаа хандуулаад байна.

Нарийн төвөгтэй зарим нэг асуудал байгаа хэдий ч яриа хэлэлцээрээр дамжуулан шийдвэрлэж Оюу Толгой төслийг амжилттай хэрэгжүүлэх амлалтаа хамтдаа хэрэгжүүлнэ гэдэгт би итгэл дүүрэн байна.

Бусад хөрөнгө оруулагчид юу хүсэж байгаа вэ?

Энэ амлалтад хөрөнгө оруулагчид ашиг хүртэх боломжийг хангах, хамгийн чухал нь Монгол улсын ирээдүйн хөгжил, цэцэглэлтэд ихээхэн хувь нэмэр оруулах явдал орж байгаа.

Надтай уулзаж ярилцсан олон бизнес эрхлэгч энэ хөгжлийн үйл явцад оролцох хүсэлтэй байгаагаа илэрхийлж байсан. Тэдний дунд Монголын бизнес эрхлэгчид, олон улсын хөрөнгө оруулагчид аль аль нь л байсан. Гэхдээ Монгол улсын цаашдын хөгжлийн тулгуур болсон гурван зүйлийг тэд онцолж байсан юм.

Нэгдүгээрт, тэд бүгдээрээ Монгол улсад хөрөнгө оруулалтыг татахад чиглэсэн хууль эрхзүйн тогтвортой байдлыг хүсэж байсан.

Гадаадын шууд хөрөнгө оруулалтын бодлогын бичиг баримтыг боловсруулж, ашигт малтмалын шинэ хуулийг баталж, хөрөнгө оруулалтын хуулийг шинэчлэн найруулах нь маш сайн хэрэг. Бизнес эрхлэгчдийн санаа зовоосон зарим асуудлууд бий ч эдгээр нь Засгийн газар илүү их хөрөнгө оруулалт татах амлалтаа хэрэгжүүлж байгааг харуулах хүчтэй дохио бөгөөд Монгол улсад байгаа бизнес эрхлэгчид үүнийг эхний алхам хэмээн сайнаар хүлээн авч байна.

Хоёрдугаарт, Монгол улсыг олон улсын хөрөнгө оруулалтын газрын зураг дээр байлгахын тулд Оюу Толгой төслийн санхүүжилтийг амжилттай хэрэгжүүлэхийг бизнес эрхлэгчид хүсэж байна. Энэ нь өөрийн эрх ашгийг бодсон мэт харагдаж болох ч Оюу Толгой төслийн санхүүжилт Монгол улс томоохон төслүүдэд санхүүжилт авах үйл ажиллагааг илүү хялбар болгох банк санхүүгийн цогц харилцааг бэхжүүлнэ гэдгийг бусад бизнес эрхлэгчид мэдэж байгаа хэрэг. Монгол улсын эдийн засаг, бизнесийн ирээдүйн амжилтын үндэс бол амжилттай хэрэгжиж байгаа Оюу Толгой гэдэг нь тодорхой юм.

Гуравдугаарт, тэд эдийн засгийн өсөлт, хөгжилд оруулж буй бизнесийн байгууллагуудын болон, бизнесийн байгууллагуудад тогтвортой ашиг олох бодлогын үүрэг ролийг хүлээн зөвшөөрөхийг хүсч байна. Эдгээр бодлогод, хууль засаглалыг дээдлэх, гэрээ хэрэгжүүлэх баталгаа, бизнес эрхлэх тогтвортой, урьдчилан таамаглаж болох орчныг бүрдүүлэх зэрэг орно.

Магадгүй Монгол улсын түүхэнд хамгийн их ярьж, хэлэлцсэн гэрээ бол Оюу Толгойн түншлэлийн суурийг бүрдүүлэгч Оюу Толгойн Хөрөнгө оруулалтын гэрээ болов уу. Оюу Толгой Монгол улсын хамгийн том хөрөнгө оруулалт учраас бид амлалтаа хэрхэн хэрэгжүүлж байгаа талаар яриа хэлэлцүүлэг өнөө хэр явагдаж байгаа бөгөөд цаашид ч үргэлжлэх нь хэвийн үзэгдэл юм.

Түүнчлэн Хөрөнгө оруулалтын гэрээ нь хөрөнгө оруулагчид болон Монгол улсад ирээдүйн хөгжил, цэцэглэлтийг бий болгох хамгийн сайн арга хэрэгсэл мөн эсэх талаар яриа хэлэлцүүлэг өрнөх нь ойлгомжтой.

Хөрөнгө оруулалтын гэрээ Оюу Толгойн суурийг бүрдүүлсэн хэвээр байх бөгөөд олон улсын хөрөнгө оруулагчид болон Монгол улсын хувьд аль алинд нь ашиг тусаа өгч чадна гэдэгт би хувь хүнийхээ үүднээс бүрэн итгэлтэй хэлэх байна.

Ирээдүй

Монгол улс болон олон улсын хөрөнгө оруулагчид аль аль нь Оюу Толгойг онцгой амжилттай хэрэгжүүлж уул уурхайн болон өсөлт хөгжлийн шилдэг жишээ болгоно гэдэгт би итгэлтэй байна. Ингэснээрээ Монгол улсыг хөрөнгө оруулалт хийх таатай газар хэмээн тунхаглах томоохон хэмжүүр болох юм. Монгол улс бол чинээлэг иргэдтэй, хөгжиж цэцэглэх гэрэлт ирээдүйтэй улс орон.

Монгол улсын байгалийн баялаг өндөр чадамжтай, эрэлт хэрэгцээтэй. Хятад болон Энэтхэг улсын өсөлт хөгжил, түүнийг дагасан эрэлт хэрэгцээ нь дунд болон ойрын хугацааны ашигт малтмалын үнэ ханшийн талаар ихээхэн найдвар төрүүлж байна. Энэ эрэлт хэрэгцээг ханган нийлүүлэх хүн хүч, нөөц баялгийн болон газарзүйн хувьд Монгол

улс төгс байрлалтай бөгөөд дэлхийн тавцанд манлайлагч болон гарч ирэх бүрэн боломжтой юм.

Би арван жилийн дараа Оюу Толгойг Монгол улсын хөгжил цэцэглэлт болон ард иргэдийн амьдралд ихээхэн хувь нэмэр оруулдаг, төрөлжсөн эдийн засгийн идэвхтэй бизнесийн салбарын нэг хэсэг болсноор төсөөлдөг. Энэ алсын харааг бид хамтдаа хэрэгжүүлж чадна.